

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**«УЙГУР ҮНДЭСТНИЙ ТҮҮХИЙН
МАТЕРИАЛЫН ТОВЧ» Бээжин. 1977
(Шүүмж)**

БНХАУ-ын түүхч Фэн Зяшэнь, Чэн Суло, Му Гуанвэнь нарын зохиосон 177 хуудастай эл номыг Бээжингийн үндэстний хэвлэлийн хорооноос эрхлэн 1981 онд хятад хэл дээр хэвлэн гаргалаа.

Уг ном есөн бүлэгтэй. Уйгурын гарал үүсэл, уйгур аймгууд бүрэлдэн тогтсон түүх ба тэдний оршин амьдарч байсан газар нутаг зэргийг өгүүлжээ. Номд уйгур бол түрэгийн олон үндэстний нэг салбар бөгөөд манай эриний өмнөх III зуунаас МЭ-ий III зууний хооронд Дин лин гэдэг нэрийн дор баруун зүүн хоёр хэсэгт хуваагдаж байв. Зүүн хэсэг нь нүүдэлийн мал аж ахуй эрхлэн Сибирь,¹ Байгаль нуурын өмнөт талаар, баруун хэсэг нь мөн мал аж ахуй эрхлэн Эрчис голын орчмаар нутаглаж байлаа. Тэд нар хүннүгийн захиргаанд байхдаа түүний дарлалыг байнга эсэргүүцэн тэмцэж байсан юм гэж бичжээ.

Уйгурын хамгийн гол язгуурын овог дотоод есөн үндэстний нэгдэл юм. Түүнийг хаан толгойлно. Энэ есөн үндэстний нэгдэлийг уйгур гэж нэрлэдэг. Гадна есөн аймаг бол уйгур ба бусад найман аймгуудаар бүрдэл болдог үүнийг уйгур аймгийн ахлагч тэргүүлнэ. (11-р тал)

Уйгур нь Орхон, Сэлэнгэ голын хооронд нутагласаар ирсэн юм. (11-р тал) Уйгур ард түмэн нүүдлийн мал аж ахуй эрхлэн Орхон, Сэлэнгэ голын хооронд 4-5 зуун жил суусан. (14-р тал). Нүүдлийн мал аж ахуй нь уйгурын эдийн засгийн гол салбар болж байв. (23р тал)

744 онд Пэйло биеэ Куль билгээ хэмээх цолтой хаан болгон өргөмжилж, уйгурын хаант улсыг байгуулж, Орхон голын хөндийд нийслэлэн, түүний нутаг дэвсгэр нь Дорно зүгт Хянгакы нуруу, баруун зүгт Алтайн уул хүрч байв. Уйгурын хаант улс хамгийн их мандсан үедээ, зэвсгийн хуч нь Дундад Ази хүрч сайв гэж уйгурын хаант улсыг дайнч улс болгон дүрсэлжээ. (14-р тал) Уйгур нь Тан улстай найрамдалт харилцаатай байсан хийгээд Өрнө Дорнын хоорондын харилцааны замыг эзэмшиж байсны үрээр уйгурын нийгэм, эдийн засаг их өөрчлөгдөж, унгур нь нүүдлийн байдлаас хагас суурин байдал руу хандаж мал аж ахуй нь бас худалдаа руу чиглэсэн юм гэж бичээд (23-р тал) нэг хуудас алгасаад Уйгур, Тангийн хооронд худалдаа хийж байсныг дурдаад уйгурын эдийн засгийн хөгжил нь Тан улстай худалдаа хийсний үр дүн мэтээр дүгнэн бичсэн байна. (24-р тал)

Уйгурын хөгжлийн шалтгаан (сурвалж) нь: Тан улстай энх тайвнаар худалдаа хийж тэнд морины зах гарган Тан улсаас цай, торго авч байсан нь уйгурын эд баялгийг нэмэгдүүлсэн юм (24-р тал) гэж өгүүлжээ.

Бас Уйгурын соёл, хэл бичиг, шашны талаар бичихдээ: Уйгур нь анх бөөгийн шашиыг шүтэж байсан юм. (34-р тал) Манийн шашныг манай эриний III зууны үед Персийн Мани гэдэг хүн анх үндэслэсэн бө-

¹Уйгур нь сибирь хүртэл хэзээ ч нутаглаж байгаагүй юм. (А. Х.)

гөөд уг шашин нь VII зууны үед Тан улсад дэлгэрч, 763 онд Тан улсаас уйгурт нэвтрэн дэлгэрчээ (34-р тал) гэж бичсэн байна.

Гэтэл энд өгүүлж байгаа баримт нь хоорондоо ихээхэн зөрж байна. Манийн шашин 763 онд Тан улсаас Уйгурын хаант улсад нэвтрэхээс бүр өмнө Уйгурын Моюнчур хаан айл хөрш орших Тан Улсын хүсэлтээр нэргийн тусламж үзүүлж 759 онд (уйгурын) Моюнчур хаан Тан улсад гарсан Ань Шигийн бослогыг дарахад туслаж босогчдоос Лоянь хотыг эргүүлэн авч, Хэбэйг төвшитгөж, анх удаа Манийн шашныг Тан улсад дэлгэрүүлж, (Моюнчур) өөрийгөө (Манийн) шашны тэргүүн болгов» гэж энд өгүүлсэн байна (21-р тал)

Энэ үеэс манийн шашны сүм хятадын шар мөрөн болон хөх мөрний урсгалын дагуух нутаг газруудаар барьж байсан ул мөр үлдсэн юм гэжээ. Тан улсын Да ли хааны 3-р оны 6-р сарын 29-ны өдрийн зарлигаар уйгурын манийн сургаалыг эрхэмлэн шүтэж байхаар (768 онд) «Да юн гуанмин» гэдэг манийн сүм байгуулжээ. Мөн хаан 771 онд «Их үүлэн туяа» гэдэг сүм барьсан. 806 онд Тан улсын хаан манийн шайшыг хүндэлж манийн шашныг нийт улс орон даяар хэрэглэх болгож манийн шашны гэлэн нартай улсын асуудлыг байнга зөвлөж байх, Тан улсын нийслэлд Манийн сүм барьсан тухай өгүүлжээ. Үүнээс үзэхэд манийн шашин нэн түрүүн Перстэй хамгийн өргөн харилцаатай байсан уйгурт эхлэж нэвтрээд дараа нь Тан улсад дэлгэрсэи байна. Учир нь Персийн манийн шашны гэлэн нар Тан улсад очиход уйгурын нутгийн захаар дайрч өнгөрөх ёстой ба үүнээс өөр замаар Дунд Азиас Хятадад очих аргагүй байжээ. Иймээс манийн шашны гэлэн нар уйгурт уг шашнаа анх түрүүн дэлгэрүүлээд дараа нь аажмаар тан улсад нэвтрүүлсэн хэрэг.

Гэвч Уйгураас Тан улсад манийн шашин дэлгэрсэн гэх нь Маогийнхны жанжлах дээрэнгүй үзэлд мэдээж таалагдахгүй байгаа бололтой.

Харин Тан улс Уйгурын хаант улсаас тусламж авахад нь Уйгурын хаан Моюнчур манийн шашныг тэр тусламжтай хамт Хятадад нэвтрүүлснийг энэ номонд өгүүлсэн баримт гэрчилж байгаа юм.

840-өөд онд уйгурууд Орхоноос баруун тийш Тэнгэр уул, ГаньЛяний хооронд нүүж очсон тухай өгүүлээд баруун тийш нүүж очсоны дараагаас эхлэн тэд Дорно Өрнийн зам харилиааны чухал газар орших болсон тул нийгэм, эдийн засаг нь шинээр хөгжсөн юм (62-р тал) гэж өгүүлсэн байна.

X зууны эхнээс XII зууны дунд үе хүртэл уйгурууд нь хөдөө аж ахуйн болон гар үйлдвэрийн олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чаддаг болжээ. Жишээлбэл: уул уурхай, эмийн зүйл болон олон төрлийн үнэртэн үйлдвэрлэж гаргадаг болсон байна Уйгур нь эдгээр бүтээгдэхүүнээрээ Хятад, Кидан, Зөрчидтэй удаан хугацааны турш арилжаа худалдаа хийсэн ба нэн ялангуяа умард Сун улстай бүр ч их худалдаа хийж байв. Уйгурт Хан үндэстний нийгэм, эдийн засгийн нөлөө маш их байсан (62-р тал) гэжээ. Уйгур нь баруун тийш нүүсний дараа X-XI зууны үед Перс, Энэтхэг, Араб, Ром, Хятадтай эдийн засаг, соёлын харилцаа нь цэцэглэн хөгжив (62-р тал) гэжээ.

840-өөд онд (39-р тал) Уйгур нь баруун тийш нүүсний дараа анх эртний түрэг бичиг авч хэрэглэн, тэгээд дараа нь аажмаар согд бичгийн цагаан толгойг ашиглан эртний уйгур бичиг зохиосон юм (84-р тал) гээд цааш бичихдээ: Уйгурын бичиг үсгийн талаар дурдахдаа уйгур нь баруун тийш нүүсний дараа уйгур бичгээс хэрэглэж байснаас гадна Сири, Перс, Санскрит, Грек, Түрэг, Хятад Мани зэрэг бичгийг хэрэглэн ном бичиж байсан.» (86-р тал) хэмээн өгүүлээд уйгурын бичиг үсэг чухам хэдийд хэрхэн яаж үүссэн тухай дурдахдаа зайлсхийж нэг л олон төрлийн бичиг хэрэг-

лэж байсан мэт дурдаад чухам ямар ямар ном хэвлэж байсан тухай иш үндэс болгох тодорхой баримтыг хэлээгүй орхисон байна. Зохиогч уг номондоо уйгурын хаант улс Орхон голын хөндийд оршин тогтнож байхдаа ямар нэгэн бичиг үсгийн соёл тэдэнд байгаагүй гэж түүхэн бодит үнэнийг гуйвуулж, уйгур ард түмнийг илэрхий басамжилсан байна.

Иймд уйгурын хаант улсын түүхэн үнэн чухам ямар байсныг хойно баримтаар өгүүлэе. Уйгурууд Монгол нутагт оршин тогтнож байсан олон улсуудын дотроос нэлээд дээгүүр өндөр соёлтой нь байв. Уйгурын соёлын тухай дурдахад өмнөх үе хүннү, түрэгийн соёлоос салган үзэж болохгүй, түүнийг шууд уламжлан авч цааш баяжуулж байсан гэж үзвэл зохино.

Уйгурын соёл харьцангуй өндөр хэмжээнд байсан нь түүхийн зохиол, эртний судлалын хэрэглэгдэхүүн зэргээс илэрхий байна. Төмөрийн хүдэр малтан төмөр боловсруулж чаддаг байсан нь уйгурын соёлын хөгжилд их нөлөө үзүүлжээ.

Уйгурын хаант улсаас тус улсын нутагт үлдээн хоцроосон соёлын өв дурсгал болох эртний түрэг-үсгээр бичсэн уйгурын гэрэлт хөшөө, хот суурины үлдэгдэл, булш бунхан элбэг байна.

Уйгур нар баруун тийш нүүхээс бараг зуугаад жилийн өмнөөс эхлэн босгосон түрэг бичигтэй гэрэлт хөшөөнүүд нь эдүгээ БНМАУ-ын нутаг дээр уйгурын соёлын гайхамшигт дурсгал болон одоо хүртэл хадгалагдсаар байна. Тэдгээрийн дотроос заримыг дурдвал:

«Сэлэнгийн чулуу» гэж алдаршсан хөшөө нь Хануй, Хүннү хоёр голын бэлчирт цутгагч Могойн голын эхэн Шинэ ус гэдэг газар оршино. Тэрхүү бичээсийг 1909 онд Монголд хэл бичгийн шинжилгээний ажлаар явсан Финляндын нэрт монголч эрдэмтэн Рамстедт олжээ. Уг хөшөөнд Моюнчур хааны үеийн (747-759 он) уйгур улсын дотор болсон гол үйл явдлуудыг тоочин бичсэн учир уйгурын мандсан үеийн түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүний нэг болсон юм. «Тариатын хөшөө» уйгур улсыг байгуулахын төлөө тэмцэлдсэн 741-745 оны үйл явдал болон 745-753 онд явуулсан аян дайн зэрэг арван хэдэн жилийн дотор болсон түүхэн үйл явдлыг харуулжээ.² Тэсийн голын эргээс олдсон «Тэсийн бичиг» нь 760-780-аад оны үеийн эртний уйгур улсын хэрэг явдлыг дурджээ.² Үүнийг 1976 онд Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын нутгаас олсон байна. «Карабалгасуны дурсгал» нь эртний уйгур улс хэрхэн мөхөх болсны шалтгааныг хураангуйлан өгүүлжээ.³

Эдгээрээс үндэслэн Уйгарууд баруун тийш нүүхээсээ өмнө монгол нутаг дээр төр улсаа байгуулан, түрэг бичиг хэрэглэж байсан гэдгийг гадаад дотоодын судлаачид эрдэм шинжилгээний бүтээлүүддээ нэгэн дуугаар батлан тогтоосон билээ.

«Орхон бичээс» одоогоос 300 гаруй жилийн өмнөөс эхлэн олон улсын эрдэмтдийн анхаарлыг татсаар ирсэн юм. Голландын хууль цаазач, Амстердам хотын дарга Н. К. Витзен (XVII зуунд), Оросын газар зүйч С. У. Ремезов (XVII зууны үед) нар анх «орхон бичээс» буюу «орхоны чулуу»-ны руни-түрэг бичгийн тухай бичиж байсан. Түүний дараа Шведийн Ф. И Табберт-Страленберг, Оросын жуулчин П. С. Паллас (1768--1774), Н. М. Ядринцев, В. В. Радлов, Клеменц, Мелиоранский, Котвич, Рамстедт нар болон С. Е. Малов, П. Пельо, Г. Е. Грумм-Гружимайло, В. В. Бартольд, Б. Я. Владимирцов, Х. Н. Оркун, С. П. Толстов, А. М. Бернштам, С. В. Киселев, А. Габан, Томсон, Дж. Класон, Лиу Мауцай, В. М. Насилов, П. Гирауд, С. Г. Кляшторный, Э. А. Макаев, А. Н. Ко-

²М. Шинэхүү Орхон-сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, УБ. 1980, 22-р тал

³Мөн тэнд. 56-р тал. 3. Мөн тэнд. 57-р тал.

нонов, М. Шинэхүү нарын зэрэг олон эрдэмтэд орхоны бичгийг нарийвчлан судалж, Төв Азийн нүүдэлчин ард түмний түүхэнд холбогдох чухал сурвалж бичиг соёлын өв, эртний уйгур хэлний ховор нандин дурсгал хэмээн үзэж, цаашид судалгаа хийх явдал одоо хүртэл үргэлжилсээр байна.

Энэ номонд Монгол, Уйгур хүмүүс согдын цагаан толгой авч хэрэглэсэн тухай түүхэн он цагийг гажуудуулж бичихдээ: «Уйгурууд 840-өөд онд баруун тийш нүүж очсноос хойш аажмаар согд цагаан толгой ашиглан эртний уйгур бичиг зохиосон юм» (85-р тал) гэжээ. «Монгол бичиг бас л уйгурын цагаан толгойг хэрэглэн зохиогдсон юм» (85-р тал) гэж бичээд цааш нь үүнийгээ баримттай болгох гэж тайлбарлахдаа Монголчууд бичиг үсгийг уйгураас авсан бөгөөд түүний дурсгалыг Францын Рубрукын «Дорно зүгт аялсан замын тэмдэглэл»-д дурдсан 1250-аад оны үеийн «Мөнх хаанаас ирсэн монгол үгээр уйгур үсгээр бичсэн захидал»-ыг Монголчууд уйгур бичиг авч хэрэглэсний анхны баримт болгож энд зориуд оруулсан явдал нь санамсаргүй зүйл бишээ.

Энэ бол Монгол, Уйгур зэрэг нүүдэлчдийн бичгийн соёлыг үл тоомсорлон басамжилсан санаа агуулж тэдгээрийг эрт үед бичиг үсэггүй байсан-болгох гэж чармайж тэдний бичиг үсгийн гарлын он цагийг аль болохоор наашлуулахыг оролдож байгаа нь илхэн харагдаж байгаа юм. Гэтэл түүхийн бодит байдал чухам ямар байсан вэ гэвэл «Согдчууд Төвдөөс Монгол хүртэл төв Азийн бүх нутаг даяар худалдаа, эдийн засаг, шашин суртахууны болон газар нутаг эзэмшин суурьших ер бусын өргөн хүрээтэй бөгөөд идэвхтэй үйл ажиллагааг явуулж байсан нь сайн мэдэгдэж байгаа билээ»⁴

Согд нар ийнхүү төв Азийн нүүдэлчдийн соёлын ертөнц-д өргөн хүрээтэй асар их нөлөө үзүүлэх түүхэн таатай нөхцлийг бүрэлдүүлсэний үрээр уйгур, Монгол хүмүүс эртний согд бичгийг авч хэрэглэжээ. Уйгур бичгийн гарлын тухайд Зөвлөлтийн эрдэмтэн А. Махмутов 1969 онд бичсэн судалгааны нэгэн зохиолдоо «...Вишбаликын баян бүрдээр нутаглаж байсан уйгурууд барагцаалахад V зууны үед согд цагаан толгойгоос эртний уйгур үсэг авчээ.» хэмээн бичсэн нь эргэлзээ төрүүлэхгүй байна.⁵ Үүнийг судалгааны материалууд улам бүр тодотгож байна.

Монгол хэлэнд орсон иран үгийн талаар 1919 онд Б. Лау-ферийн⁶ судалгаа гарсны дараа акад. Б. Я. Владимирцов нарийвчлан судлаад уйгур, монгол хэдэнд байгаа, гол төлөв шашны самгард нэр томъёо согдоор дамжиж орж ирсэн байна гэдэг маш нягт дүгнэлт хийсэн билээ.⁷

Акад. В. Я. Владимирцовын энэ нарийн дүгнэлттэй холбоотой нэгэн сонин мэдээг Г. И Рамстедт 1922 онд Монгол хэлээр гарсан «Уйгур улсын хураангуй түүх»⁸ гэдэг номдоо оруулсан бөгөөд үүнээс нь түүхч Дамдин «Hor-chos'byun»-даа авч дурдсан байдаг юм. Тэр мэдээний товч утгыг дурдвал, «Чингэс хааны үеэс даруй 700 жилийн урьдаас монгол, уйгур, согд нар их л ойр харилцаатай байсныг дурдаад согдын мэргэн багш нар уйгар хийгээд монголчуудад үсэг бичиг унших ба бурханы дээд

⁴Ш. Бира. Монгол ба төв Азийн орнууд (Монгол ба Төв Азийн бусад орнуудын соёлын харилцааны түүхийг судлахын учир): «Олон улсын монголч эрдэмтэдийн III их хурал» III боть УБ 1979 он 100-р тал

⁵Т. А. Махмутов, Как возник древнетюркский алфавит, Исследование тюркологии, Алма-Ата, 1969, с 142.

⁶В. Laufer, Sino-Iranica. Chicago. 1912.

⁷ В. Я. Владимирцов Монголия об отношении монгольского языка к индо-европейским языкам средней Азии. ЗКВ № 1 Ленинград, 1925, 305—341.

⁸Г. И Рамстедт. Уйгур улсын хураангуй түүх. УБ 1922 он

ном зарлигуудыг өөр өөрийн хэлээр орчуулах ёсыг үзүүлж сургаж, бас согд нар Энэтхэгийн орноос бурханы номыг Монгол оронд залж ирсэн бөгөөд энэ шалтгаанаар ч номын хэлэнд энэтхэг, уйгур, монгол холимгоор оршсоор байна»⁹ гэсэн байдаг.

Энэтхэгийн орноос бурханы номыг Монгол оронд залж ирсэн бөгөөд энэ шалтгаанаар ч номын хэлэнд энэтхэг, уйгур, монгол холимгоор оршсоор байна»⁹ гэсэн байдаг.

Судлагчдын онож тодорхойлсончлон тухайн цагтаа Төв Азийн Lingua Franca¹⁰ болж байсан Согд хэл бичгээр дамжуулан энэтхэгийн соёлын зүйлийг монгол, уйгар хоёр зэрэг авч хэрэглэж байсан нь дээрхи баримт сэлтээс тодорхой харагдаж байна. Зөвлөлтийн эрдэмтэн В. Истрин дэлхийн олон улсын бичиг үсгийн түүхийг улируулан судалсаар эрт цагт нэг улс нөгөөгөөсөө бичиг үсэг авах нь шашин номын хэрэгтэй холбоотой байжээ гэдэг дүгнэлт хийсэн нь уйгур монгол хоёр согдоос бичиг үсэг авсан түүхтэй зөрөхгүйгээр үл барам дээрх бүх баримтыг онолын талаас давхар баталж байгааг дурдах хэрэгтэй»¹¹ юм.

Эдгээр баримтанд тулгуурлаж үзвэл Монголчууд XIII зуунд согд үсгийг уйгураас дам авч хэрэглэсэнгүй, харин VI-VII зууны үед Монгол, Уйгур хоёр одоогийн Тажикийн дээд өвөг Согд нараас нэгэн зэрэг үсэг бичиг авсан гэдгийг батлах баримт гарч байна. Хэрэв уйгурууд Согдоос V зуунд бичиг үсэг азсан гэж нотлож байгаа А. Махмутовын судалгааг дээрхи баримттай холбож үзвэл Монголчуудын бичиг үсэг авсан он цаг даруй нэгэн зуун жилээр урагшлах болно гэж эрдэмтэн Ц. Шагдарсүрэн бичжээ.¹²

Түүнчилэн монгол хэлний үгийн санд гол төлөв самгард мөн бусад харь гаралтай, шашин номын чанартай нэр томъёо Согд, Тохараар дамжин орж ирснийг гадаад дотоодын олон эрдэмтэд нэгэн дуугаар зөвшөөрөн хүлээдэг билээ¹³ Үүнээс гадна Монгол нутгаас согд бичээсийн зүйл төдий л цөөнгүй олдож байгаа нь мөн л согд нарын нөлөөтэй байсныг давхар гэрчилж байгаа юм.¹⁴ Энэ номыг уншиж үзэхэд уйгурын түүхэнд холбогдох материалуудыг нарийн дэс дараатай биш, хэсэг хэсгээр нь энд тэндээс өөртөө хэрэгтэй зүйлийг авч нэгтгэсэн байна. Нөгөө талаар Уйгурын түүхэнд зайлшгүй байвал зохих зүйлүүдийг аваагүй орхисон явдал ч цөөнгүй тааралдаж байна.

Уйгур нь нийгэм, эдийн засаг, соёлын хөгжлөөр тухайн үед Тан улсаас дутуугүй байсан тухай олон баримт Тан улсын түүх болон бусад материалуудад байдаг. Нэг үгээр хэлэхэд уйгурын соёл иргэншил нь Тан улсад олон талаар нөлөөлж байсныг хэлээгүй орхисон байна. Уйгур хүмүүсийн амьдралын дэвшилтэд зүйл нь хятад хүмүүсийн амьдрал ахуйд нэвтэрч, Тан улсын нийслэл Чан Ань зэрэг хот газрын хүмүүс уйгурын хурдан моринд шохоорхон дурлаж, уйгур хувцас хунарыг хятад хүмүүс гоёл болгон өмсөж байв. Ялангуяа Тан улсын хааны ордны эмэгтэйчүүд

⁹Ц. Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. тэргүүн дэвтэр. УБ. 1981, 11-р тал

¹⁰P. Pelliot, La Haute Asie, Paris. 9, P. Pelliot, Les influences iraniennes en Asie central et Extreme Orient, paris. 1911

¹¹В. Истрин. Возникновение и развитие письма. Москва, 1965, с 536.

¹²Ц. Шагдарсүрэн. Монгол үсэг зүй. УБ, 1981. 11-р тал Г. И. Рамстедт. Уйгур улсын хураангуй түүх УБ. 1922. 16—17-р талд.

¹³N. N. Poppe, Introduction to Altaic Linguistics, Wiesbaden. 1963. p. 1963; V. Rinchen, Sanskrit in Mongolia. SIAAC. vol. 3: New-Delhi. p. 91

¹⁴S. G. Kljastorny, Y. A. Livsic, Une inscription inedite turque et sogdienne; La stele de sevrey. Ja 1971, Paris, 11-20.

В. В. Радлов, Атлас древностей Монголии. С—Петербург. 1902

нарийхан ханцуйтай бүсэлхийгээрээ нарийн бие барьсан уйгур хувцсыг өмсөж гоёх явдал маш их дэлгэрч байжээ. Эдийн засгийн талаар Уйгураас Хятадад цөөнгүй зүйл нөлөөлж байжээ. Шийгуа-(тарвас) тарих арга барагцаалбал X зууны үед хятадын шар мөрний дагуу газарт Уйгураас нэвтэрч хятадууд тарьж сурсан байна. Бас жимсээр архи хийх арга, хөвөн тариалах арга техник мөн уйгураас хятадад дэлгэрсэн тухай хягад сурвалж бичигт дурдсаныг энд оруулаагүй орхижээ. Ийнхүү Уйгураас Хятадад хөвөн тариалах арга нэвтэрсний үрээр хятад хүмүүс дулаан хувцас өмсөх бололцоотой болсон болон жимсээр архи хийх арга маш хурдан нэвтэрснийг огт хөндсөнгүй.

Газар тариаланг хөгжүүлэх агротехникийн нарийн арга ухаан Уйгураас Хятадад XIII зууны үед нэвтэрч хятад хүмүүс газар тариаланг эзэмших дэвшилтэд аргыг хэрэглэх боломжтой болсноор барахгүй уйгурын агрономич эрдэмтэдийн бичсэн зохиолууд хятадын хөдөө аж ахуй, газар тариаланг хөгжүүлэхэд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг түүхэнд тодорхон баримтаар өгүүлсэн байтал энэ тухай орхигдуулсан нь харамсалтай болжээ.

Зохиогчид уг номонд Тан улс улс төр, эдийн засаг, соёлын талаар Уйгурт их нөлөөлж түүний үр дүнд Уйгур улс хөгжсөн гэдэг санааг баримтгүй цулгуйгаар уг материалын завсраар шургуулахыг чармайж бичсэн нь харагдаж байна. Үнэндээ Уйгурт Тан улсаас нөлөөлсөн эдийн ба оюуны соёлын зүйлийн талаар тулгуур баримттай зүйл дурдаж чадаагүй байна. Уйгур нь Перс, Энэтхэг, Араб, Согд, Ром зэрэг эртний соёл иргэншил их хөгжсөн орнуудтай олон талаар зузаан холбоотой байсан явдал уйгурын хөгжилд ихээхэн хүчтэй нөлөөлжээ. Энэ үед харин Тан улс Уйгураас олон зүйлийн тусламж дэмжлэг авч, нэг үгээр хэлэхэд уйгурын улс төр, эдийн засаг, соёлын нөлөөг хүлээж байжээ. Үнэндээ Уйгур нь Тан улсаас давамгайл хүчтэй байсан явдлыг зохиогч аль болохоор бууруулахыг оролдсон байна.

Зохиогч Уйгурын хөгжлийн шалтгаан бол Тан улстай морины наймаа хийж, зах гаргаж, түүний оронд торго цай авч байсан явдал нь Уйгурын хөгжлийн гол шалтгаан болсон мэтээр түүхийг завхруулан тайлбарлах гэж оролджээ.

Уйгурын хөгжлийн гол шалтгаан нь Тан улс огт биш, харин өөрийнх нь үйлдвэрлэх хүчний хөгжил, нөгөө талаар эртний өндөр соёлтой Энэтхэг, Араб, Перс, Ром, Согд зэрэг орнуудтай өргөн харилцаатай байсан явдал Уйгурын хөгжлийнх нь гадаад шалтгаан болсон нь маргаангүй үнэн.

Харин Тан улсын хөгжлийн гадаад хүчин зүйл нь Уйгур улс болж байсан юм. Тан улс дотооддоо удаа дараалан гарч байсан үймээн самуунаа дарж дийлэхгүй болсон учир Уйгурын хаант улсад элч олон удаа илгээн уйгураас тусламж олон дахин гуйж авч байсныг Уйгурын болон Тан улсын түүхэнд олонтой өгүүлсэн байдаг. Уйгурууд Тан улсаас ямар нэг тусламж гуйж байгаагүй юм Энэ нь тэр үед Уйгурын хөгжилд нөлөөлөх хүч нь Дорно зүг биш Өрнө зүг байсантай холбоотой юм.

Тан улс Уйгураас морь, мал, уул уурхайн болон хувцас хунар зэрэг гар үйлдвэрийн бүтээгдэхүүн, эмийн зүйл зэргийг худалдан авч оронд нь цай, торго өгч байсан юм. Уйгураас худалдан авсан морь мал, Тан улсын газар тариаланд зүтгэх хүчин болж байсны зэрэгцээ уул уурхайн бүтээгдэхүүн зэрэг нь бусад олон чухал зүйлийн хэрэгцээг хангах хүчин зүйл илэрхий болж байлаа.

Уйгур нь Орхон голын хөндийд нутаглаж байхдаа зэргэлдээ орших аймгуудын алт, мөнгө, зэс, төмөр зоос мөнгөний хөгжлийг тусган авч

Зоос мөнгө цутгаж арилжаа худалдаанд хэрэглэж бэл хөрөнгө нь их хөгжсөн юм. (63-р тал) Ийнхүү уйгурт таваар мөнгөний систем хөгжсөн явдал нь уйгураас түрүү үеийн нүүдэлчин улсуудын мөнгөний уламжлалыг шууд залган авсны үр дүн мөн. Уйгур нь Орхон голын хөндийд эдийн засаг, соёл нь цэцэглэн хөгжсөн хүч чадалтай, хаант улс байгуулан оршин тогтнож байв.

Энэ үед уйгурын хаант улс нь өмнөт хөрш Тан улсад улс төр, эдийн засаг, соёлын талаар нөлөөлөх хүчтэй улс байсан гэдгийг баримт гэрчилж байна.

Гэтэл уг номонд уйгурын хаант улс нь Тан улстай эрх тэгш найрамдалт харилцаатай, зэрэгцэн оршиж байхдаа харилцан ашигтай худалдаа хийж байсныг зохиогч зориут мушгин гуйвуулахдаа уйгур нь гагцхүү Ган улстай найрамдалт харилцаатай, худалдаа хийж байсны үрээр хөгжсөн гэдэг зохиомол санааг энд зориут оруулж байгаа нь түүхэн үнэнд харшилж байгааг бодит баримт няцааж байна.

А.ХИШИГТ